



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2012 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

**“Тал нутгийн марафон-2012” Нийслэлийн
Засаг даргын нэрэмжит олон улсын тэмцээн
зохион байгуулах тухай**

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын аялал жуулчлал-2015” хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2012 оны 07 сарын 16-ний өдрийн А/501 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Улаанбаатар хотын аялал жуулчлал -2015” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аялал жуулчлалын идэвхитэй улирал эхэлж байгаатай холбогдуулан Улаанбаатар хотод олон улсын чанартай тэмцээн уралдааныг зохион байгуулж, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, Нийтийн биеийн тамир спортыг ард иргэдэд сурталчилах зорилгоор “Тал нутгийн марафон-2012” Нийслэлийн Засаг даргын нэрэмжит олон улсын тэмцээнийг 2012 оны 07 сарын 22-ны өдөр Нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэр “Цонжинболдог” Чингисийн морьт хөшөө цогцолборт зохион байгуулахыг эвент хариуцсан мэргэжилтэн /Г.Нямцогт/-д үүрэг болгосугай.

2. “Тал нутгийн марафон-2012” Нийслэлийн Засаг даргын нэрэмжит олон улсын тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах зардал 4.000.000 /дөрвөн сая/ төгрөгийг Нийслэлийн Засаг даргын 2012 оны 04 сарын 12-ны өдрийн А/251 тоот захирамжаар батлагдсан Үндсэний болон нийслэлийн дэд хөтөлбөрийн зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх арга хэмжээг хөтөлбөрийн дагуу цаг хугацаанд нь амжилттай зохион байгуулж, олон нийтэд хэвлэл мэдээллээр сурталчилах, хяналт тавих, шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/-д даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР

My Doc.\tushaal\.

115050000035